



## МОНГОЛ АРДЫН БОГИНО ДУУНЫ ОНЦЛОГ, ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

<sup>a</sup>Чен Нин  
«БНХАУ, ӨМӨЗО, Өвөр Монголын Багшийн их сургууль, магистр

Холбоо барих зохиогч: chenning034@gmail.com 

Хүлээн авсан: 2023.11.15

Хянагдсан: 2023.11.30

Зөвшөөрсөн: 2023.12.10

### Хураангуй

Энэхүү өгүүлэлд Монгол ардын дууны нэгэн төрөл болох богино дууны онцлог, төрөл зүйл, ач холбогдол хийгээд дунд сургуулийн 12-15 насны сурагчдын нас сэтгэхүй, хоолойн цараанд тохирсон Монгол ардын богино дуунуудыг нэмэлт хөтөлбөрийн агуулгаар сургалтад хэрэгжүүлэх боломж, арга замын тухай авч үзэв.

Монгол ардын дуу нь уртын дуу, богино дуу гэсэн үндсэн хоёр төрөлтэй. Энэ нь дууны хэв маяг, дуулах арга барилаас хамааралтай. Богино дуунууд нь ихэвчлэн хайр сэтгэл, хурим найр, тал нутгийн өдөр тутмын аж амьдрал, үйл явдлуудтай уялдаа холбоотой янз бүрийн сэдэв, агуулгатай байдаг.

Монгол ардын дууны судлал чиглэлд уртын дууны судлал нэлээд сайн хөгжсөн боловч монгол ардын богино дууны судлалын бүтээлүүд нь ерөнхийдөө түүвэр, эмхэтгэлийн шинжтэй байна. Мөн соёлын биет бус өв Монгол ардын дууны нэгэн төрөл богино дууны чиглэлээр үндэсний хөтөлбөр хэрэгжээгүй бөгөөд дунд сургуулийн хөгжмийн сургалтын хөтөлбөр, VI-IX ангийн сурах бичигт Монгол ардын богино дууны талаар цухас дурдаад орхисон байх жишээтэй.

Богино дуу гэдэг нь хэн ч дуулах боломжтой, энгийн утга найруулгатай, авсаархан бүтэц, хэлбэртэй, дууны аялгуу нь уянгалаг, сурахад амархан бөгөөд эрт дээр үеэс өнөөг хүртэл уламжлагдан ирсэн Монгол ардын богино дуунууд нь хүний сэтгэл зүрхийг татах, уяраан тайтгаруулах увдистай. Гэвч богино дууны онцлог, төрөл зүйлийг ялган таньж, ялангуяа дунд сургуулийн суралцагчдын нас, сэтгэхүйн онцлог, хоолойн цараанд хэр тохирч байгаад шинжилгээ хийсэн судалгаа дутмаг байгаа нь өнөөгийн тулгамдсан асуудал юм.

### Түлхүүр үг

Хөгжмийн боловсрол, агуулга, арга зүй, сургалтын хөтөлбөр, сурах бичиг

## Удиртгал

Энэхүү өгүүлэлд Монгол ардын богино дууны онцлог, төрөл ангиллын талаар эрдэмтэн судлаачдын судалгааг тоймлохын зэрэгцээ дунд сургуулийн хөгжмийн сургалтад сурагчдын нас бие, сэтгэхүй, дуу хоолойн онцлогт тохирсон, тэдний гоо зүй, хүмүүжил, төлөвшилд ач холбогдол бүхий Монгол ардын богино дуунуудаас сонгон заах нэгэн боломж, арга замыг дэвшүүлж байна. Ялангуяа, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Монгол дунд сургуулийн VII-IX ангийн жишээн дээр нэмэлт хөтөлбөрөөр заан сургах боломжтой юм.

Хөгжмийн боловсрол нь суурь боловсролын чухал хэсэг бөгөөд тэрээр сурагчдын сэтгэл зүй, гоо зүйн мэдрэмж, таашаалыг хөгжүүлэх, улмаар сэтгэцийн эрүүл мэнд, өсөлт, хүмүүжил төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хөгжмийн сургалт урьд өнөө үед даяаршиж буй нийгэм, соёлын орчинд чухлаар тавигдаж байна. Даяаршиж буй дэлхий нийтийн хамтын цогц (2012 оны 11-р сард БНХАУ-ын Эв хамтын намын 18-р их хурлаас дэвшүүлсэн), эдийн засгийн интеграц, боловсрол ба даяаршлын ерөнхий чиг хандлагад бага, дунд сургуулийн хөгжмийн боловсрол, сургалтад үндэсний шинж чанарыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх, хадгалах, хамгаалах, үндэсний хөгжмийн сургалтын нөөц хэрэглэгдэхүүн бүрэн дүүрэн ашиглах, үндэсний язгуур өв соёл, уламжлалыг өвлөн авах нь өнөөгийн бага, дунд сургуулийн хөгжмийн сургалтын шинэчлэлийн тулгамдсан асуудал юм.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл тасралтгүй сайжрахын зэрэгцээ дунд сургуулийн дуу хөгжмийн боловсрол, сургалтын агуулгад үндэсний дуу хөгжмийн агуулга улам цөөрч байна. Жишээлбэл, гадаадын дуу хөгжмийн олон урсгал төрөл нэвтрэхийн зэрэгцээ, монгол ардын дууг хятад хэлээр орчин үеийн хэв маягаар орчуулан дуулах нь түгээмэл байна. Ялангуяа, хятад үндэстний шинэ маягийн дууны урсгал чиглэл, хүүхэд залуучуудын анхаарлыг татаж байна. Мөн нөгөө талаар мэдээлэл харилцааны технологийн тусламжтай орчин үеийн дууг сурагчид ихээхэн сонирхох болсон нь Монгол ардын дуу хөгжмийг хөгжүүлэх, дэлгэрүүлэхэд тодорхой саад бэрхшээл учруулж байгаа нь хариулт нэхсэн тулгамдсан асуудал болж байна.

Мөн Монгол Улсын тухайд судлаач Н.Долгорсүрэн “Монголын хөгжмийн сургалтын хөтөлбөрийн хөгжил, чиг хандлага, судалгаа, үр дүн” (2019) сэдэвт бүтээлдээ бага, дунд ангийн хөтөлбөрийн агуулгаар боловсруулагдсан 1-9-р ангийн хөгжмийн сурах бичиг дэх дууны урын сангаас жишээ татан харьцуулалт хийж, бага анги буюу “1-5 дугаар ангийн сурах бичигт нийт 80 дуу хуурын бүтээлээс 10 буюу 12,5% нь Монгол ардын богино дуу байна. Ийм учир 1-5 дугаар ангийн сурах бичигт Монгол ардын богино дууны эзлэх хувь бага байгаа учир сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон Монгол ардын богино дуунуудыг бага боловсролын хөгжмийн сурах бичигт оруулж өгөх хэрэгцээ шаардлага харагдаж байна. Дунд ангийн 6-9-р ангийн сурах бичгийн агуулгад 6-р ангийн дуулах, сонсох, хөгжимдөх 37 бүтээлээс монгол ардын дуу хуураас тусгагдаагүй, харин 7-р ангийн агуулга нь 100% ардын бүтээл, 8-р ангийн сурах бичиг дэх 31 бүтээлээс монгол ардын найруулгатай хоёр бүтээл, 9-р ангид 34 бүтээлээс үндэсний агуулга тусгагдаагүй байгаа нь 6, 8, 9-р ангийн сурах бичгийн агуулга хэт сонгодог мэргэжлийн урлагийн тал руугаа хэвийсэн нь харагдаж байна” (Долгорсүрэн, 2019, х.42-43) хэмээн шүүмжилсэн

нь бидний судалгааны ажлын хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг давхар нотлон харуулж байна.

## 1. Монгол ардын богино дууны онцлог

Дуу хөгжмийн үүсэл, хөгжлийн тухай судлаачид авч үзэхдээ хүний орчин ахуй, дотоод сэтгэл, ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил, хайр дурлал, баяр жаргал, зовлон гунигийн уран яруу дүрслэл, бодит байдлын тусгал хэмээн авч үздэг. Тэрч утгаараа Монгол ардын богино дуунууд нь ая, аялгууны хувьд утга агуулга, төрөл зүйлийн тухайд ч өөрийн өвөрмөц онцлогтой ажээ.

Энэхүү судалгааны ажилд БНХАУ-ын ӨМӨЗО, Монгол Улсад монгол ардын богино дууны чиглэлээр бичигдсэн онолын болон судалгааны ном бүтээлүүдийг харьцуулан судалж, монгол ардын богино дууны төрөл, хэв шинж, онцлогийг тодорхойлж, дуунуудыг ноотлон, хэлбэр, бүтэц (форма)-ийн шинжилгээ хийхийг зорьсон болно.

“Монгол дуу бол хүн төрөлхтний түүхт хөгжлөөс салангид биш, харин зүй тогтлын дагуу үүсэн хөгжсөөр иржээ. Дуу гэдэг бол улам улмаар боловсорч, эцэстээ өөрийнхөө хэлбэрийг олсон байна. Аялан дуулахын төлөө зохиосон, утга уянгын богиновтор шүлгийг монгол хүн дуу гэж нэрлэдэг юм. Монгол дууны сэдэв амьдралын гүн сурвалжтайн дээр зохиомж нь энгийн амархан байдаг билээ. Олонх дууны дотор нь давтах мөр буюу бадаг гэж бадаг байна. Харин Монгол дуунд урт, богино дуу гэж үг болоод хөгийн талаар хоёр томоохон анги болгож, хөгжүүлсээр иржээ. Ингэж ангилдаг явдал монгол дууны өөрийн үндэсний тусгай шинж нь болох юм” (Содном, 1960, х.3-4).

Судлаач Б.Содном “Монгол дууны түүхээс” (1960) бүтээлдээ: “Богино дуу гэдэг голдуу хурдны нэр юм шиг монгол дуучин бид ойлгож байсан нь дан тийм биш ээ. Гэвч Монголын богино дуунд хурдан түргэнийг илчилсэн зүйл бий нь дундажийг нь баримталбал, морины шогшоо шиг юм” (Содном, 1960, х.17-18) хэмээсэн бол алдарт дуучин М.Дугаржав “Богино дуу нийгмийн олон талт амьдралыг янз бүрийн сэдэв, агуулгаар тусгасан Монгол дууны зонхилох хэлбэр юм. Энэ хэлбэр нь өнө эртний зүйл бөгөөд анх богино дуунаас эх авч, уртын дуу болох замд орсон түүхэн явцдаа эртний богино дуу нь урт аялгаас одоо улам богино аялгад шилжсэн байна. Монголчууд богино дуугаа “шинэ дуу” гэж ялган нэрлэдэг билээ” хэмээжээ.

Түүний хэлснээс үзэхэд, богино буюу шинэ дуу нь төдий л түргэн биш, дунд зэргийн хурдад тохирох шүлгийн бүтэцтэй, аяын нийцтэй байх хэрэгтэй гэсэн үг юм. Өөрөөр тайлбарлавал, хоёр ба гурван үг бүхий дөрвөн мөр, бадаг шүлгийг огцмоор аялах аялгуутай байдаг юм гэсэн санаа ажээ.

Академич П.Хорлоо “Энэ огцом түргэн ая нь уртын дуу шиг хүн бүрийн дуулах тусгай мэргэжлийн авьяасыг шаардахгүй боловч үгийг тод хэлж, дүрийг ил гаргах онцлогтой байдаг. Өөрөөр хэлбэл, богино дууны шүлэг, дуулах ая хоёр хоорондоо маш ойрхон холбоотой, бие биедээ нөлөөлж, шүлэг нь аяын хэлбэрийг тогтоох гол агуулга юм. Ийм болохоор шинэ буюу богино дуу бол Монгол ардын дууны төрөл зүйлийн дотроос жирийн хүмүүсийн амьдралд хамгийн ойр, хамгийн баялаг, олон хувилбараар гэр орон, хээр гадаагүй хүн болгон дуулж байдаг түгээмэл хэлбэр мөн (Хорлоо, 1981, х.30) хэмээн онцолсон байна.

Харин хөгжим судлаач Ж.Бадраа 1956 онд хэвлүүлсэн “Хөгжмийн нэр томъёо” бүтээлдээ “Диапазон- чинээ” (Бадраа, 1956, х.12) хэмээн тодорхойлсон бол хожим нь “Ардын богино дуу голцуу нэг октаваас терци буюу кварт илүү цараатай байдаг бол уртын дуу хоёр октаваас кварт илүү гарах цараатай байдаг..” (Бадраа, 1998, х.104). Цараа гэж оросоор диапазонтой дүйнэ (Бадраа, 1998, х.107) гэжээ. Уртын дуутай харьцуулбал, богино дуу маань агуулгаар арай ч явцуу, гүн ухаан, шинжлэх ухааны ухамсрыг тусгахын хувьд арай гүехэн шиг байдаг билээ. Гэвч уртын дууг ардын дууны сонгодог хэлбэр гэж утга агуулгын нь гүн гүнзгий илтгэснээр Монгол ардын богино дууг үгүйсгэж, агуулга, утгы нь хомстгож, ач тусы нь багасгаж байгаа юм гэж ойлговол буруу. Харин ч Монгол ардын богино дууны хөгжлийн явцад уртын дуу гарч ирсэн гэвэл зохино (Бадраа, 1998, х.108) хэмээн Монгол ардын богино дууны үүрэг, ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ.

## 2. Монгол ардын богино дууны төрөл ангилал

Судлаач Г.Ренчинсамбуу “Монгол ардын дууны төрөл зүйл” бүтээлдээ Монгол ардын дууг А.Позднеев, А.Д.Руднев, Б.Я.Владимирцов зэрэг оросын монголч эрдэмтэд судалж, Монгол ардын дууг утга зохиол талаас хэрхэн ангилсныг тэмдэглээд, өөрийн ангиллыг дэвшүүлжээ. Үүнд:

“Монгол ардын дууны утга агуулгыг харгалзан, ардын дууг үндсэнд нь есөн төрөл зүйл болгон хувааж болох мэт. Нэгдүгээрт. Утга уянгат дуу. Үүнд:

1. Гүн ухааны уянгат дуу
2. Нийгэмлэг, улс төрийн уянгат дуу
3. Магтуу уянгат дуу
4. Амрагийн уянгат дуу багтана.

Хоёрдугаарт. Аж байдлын уянгат дуу. Үүнд:

1. Элбэрэл журмын уянгат дуу
2. Учралт уянгат дуу
3. Сургаалт уянгат дуу
4. Эмгэнэлт уянгат дуу
5. Хэв заншлын уянгат дуу багтана.

Гуравдугаарт. Хөдөлмөрийн дуу

Дөрөвдүгээрт. Хувьсгалын дуу

Тавдугаарт. Түүхэн дуу. Үүнд:

1. Нийгэмлэгийн түүхт явдлын дуу
2. Түүхт хүний тухай дуу багтана.

Зургаадугаарт. Эмээлийн дуу. Үүнд:

1. Цэрэг эрийн дуу
2. Сайн эрийн дуу багтана.

Долоодугаарт. Шог хошин дуу. Үүнд:

1. Нийгэмлэгийн шог дуу
2. Хүний дутагдлын шог дуу
3. Амрагийн хошин дуу
4. Магтаал хошин дуу багтана.

Наймдугаарт. Шажны дуу. Үүнд:

1. Шарын шажны дуу
2. Бөөгийн шажны дуу багтана.

Есдүгээрт. Бичгийн гаралтай дуу эдгээр болно (Ренчинсамбуу, 1959, х.13-14) гэжээ. Судлаач Д.Өрнөхдэлгэр ардын богино дууны онцлогийг тодорхойлохдоо “Ардын богино дууг жирийн амьдралын явцад хэн бүхэн сурч дуулж болдог сайн талтай. Алтайн урианхайн ардын богино дууны сэдэв нь залуусын хайр сэтгэл, түүнтэй холбоотой адал явдлыг голлон өгүүлдэг” (Өрнөхдэлгэр, 2014, х.5) гэсэн байна.

Хөгжим судлаач, доктор, профессор Ж.Энэбиш “Ардын богино дууны аялгуу байгууламжийн онцлог нь дууны шүлгийн өргөлт бүхэнд аялгууны хэм хэмнэлтийг яв цав нийцүүлж дуулдагт оршино. Дууны шүлгийн бүтэц, ая байгууламжаас шалтгаалан, монгол ардын богино дууны хэлбэр зохиомж янз бүр, угсаатан, ястны дуунууд ч өөр өөрийн өвөрмөц онцлогийг хадгалсан хэлбэр, бүтэц, аялга, хэмнэл үүсгэж, хөгжиж иржээ. Ойрдын богино дуунд тэгш болон тэгш бус хэмнэл зонхилдог бол буриад дуу бүжиглэлийн хэмнэл, аялгууны чимэг, нугалаагаар арвин билээ. Аялга хэмнэлийн ийм онцлог үзэмчин, барга болон дархад, хотгойд дуунд ч нэгэн адил хамаарагдана. Гэтэл халхын богино дуу аялгууны хөгжүүлэг, бүтэц, зохиомжоороо эрс ялгагдана. Халх богино дууны зохиомжийн онцгой хэсэг бол дахилт, давталт, хандсан үг юм. Дахилт нь гол төлөв бадгийн эцэст байдаг бол хандсан үг дууны шүлгийн аль ч хэсэгт байж болно. Төв халхын богино дуунд хайртай хүндээ хандсан “хонгор минь дээ”, “үр минь дээ”, “ай хөөрхий минь дээ” гэж онцолж хэлсэн дотно аялга үг, “Ай Сүнжидмаа минь”, “Ай Хандармаа минь дээ” гэх мэт тодорхой хүний нэр зааж хэлсэн, хандсан үгс цөөн бус тохиолдоно.

Судалгаанаас үзэхэд дотно аялга үг нь дууны шүлгийн шад мөрийн эцэст, хандсан үг нь бадгийн дунд хэсэгт байрлалтай байна. Жишээ нь, “Ай нан аа” дуунд:

“Зүүн уулын маань зэрэглээ байнаа хөө

Ай нан аа хө хө

Зүглээд очиход үгүй байнаа хөө

Зүүд нойрондоо хоёулаа байнаа хөө

Ай нан аа хө хө

Зүүдлээд сэрэхэд ганцаараа байнаа хөө...” гэх мэт ажээ.

Энэхүү жишээнээс үзэхэд дахилт болон хандсан үгийн гол зорилго нь аялгууг хөгжүүлэх, дууны шүлгийн агуулгыг гүнзгийрүүлэх, үйлийн эзний учир шалтгааныг тодруулах зориулалттайгаар зохиогджээ гэж үзэж болох юм.

Монгол ардын богино дуунд хөгжмийн үндэсний сэтгэлгээ, өвөрмөц намба төрх суулгаж байгаа бас нэг чухал хүчин зүйл бол шүлгийн төгсгөл дэх “Хө аялга” юм. “Хө” аялгыг ямар тохиолдолд дуулдгийн учир шалтгаан, уран сайхны нууцыг бид бүрэн тайлж чадаагүй байна. Гэвч энэ асуудлыг манай хөгжим судлаачид сүүлийн үед ихээхэн анхааран судлах боллоо. Хө аялга бол “Яруу найргийн үг хомсдож, аялгуунд гүйцээж оруулсан зүгээр нэг хий дэмий дайвар чимэг огт биш юм” (Н.Жанцанноров. “Талын дуулал” сэтгүүл. 1982.№3) гэжээ. Харин монгол дууны “хө”-гийн хамгийн гол онцлог бол үгээр илэрхийлж үл болох санаа, шүлэгт гаргаагүй сэтгэлийн догдлолыг хөгжмөөр нөхөн гүйцээж байгаад оршино хэмээн ойлгож байна.

Монгол ардын дууны нэгэн гайхамшиг бол утга гүн, уянга яруу, уран тансаг үг

юм. Ардын урт, богино аль ч дууны үг бол амьдрал, үзэгдэл явдлын гадаад өнгөн байдлыг төдийгүй, дотоод мөн чанар, гүн нарийн холбоог адилтгал, зүйрлэл, харьцуулалт, бэлгэдэл, егөөдлийн хэрэгслээр ой ухаанд мөнхөрч, сэтгэл санаанд шингэтэл хурц тод илэрхийлсэн байдгаараа онцлог юм. Монгол ардын дуу нь үлгэр домог, ерөөл магтаал, түүхэн үйл явдал, түүхэн болон эгэл хүмүүсийн бодит дүрийг дүрслэн харуулахдаа ашигласан байдаг учраас гоо зүйн төдийгүй танин мэдэхүй, сурган хүмүүжүүлэх, хүнийг хүн болгон төгөлдөржүүлэх хосгүй удвасыг агуулсан байдаг юм (Энэбиш, 2017, х.206-207) хэмээсэн байна.

Монгол үндэстэн, ястан, угсаатны бүлгүүдийн ардын дууны нэг бүрэлдэхүүн хэсэг нь ардын богино дуу бөгөөд тэдгээрийн онцлогийн тухайд товч авч үзье. Үүнд:

Дөрвөд дууны төрөл зүйлийн нэг нь “магтаар” буюу богино дуу юм. Энэ нь нийгмийн хөгжлийн явцад ард түмний амьдрал ахуй, анги, нийгмийн онцлог, ертөнцийг үзэх үзэл, хүсэл мөрөөдөл, шашин шүтлэг, янз бүрийн гэм дутагдал, шударга бус муу муухайг нийгэм олноороо ухамсарлан жигшиж, олны өмнө даажигнан инээдэм болгосоор ирсэн байдаг.

Хошин шог, богино дууг манай улсын олон ястан, угсаатанд янз бүрээр нэрлэж байжээ. Тухайлбал, баядад “мактаар”, “шалиг”, “шагшуур” гэх зэргээр гурван янзаар ялган нэрлэдэг бол дөрвөд, хотон ястанд “мактаар”, захчинд “кокир”, торгуудад “харганайн”, халхад “шалиг”, “завхай” гэх зэргээр нэрлэдэг байсан нь манай улсын олон ястнууд “хошин шог” дууг үлэмжхэн сонирхож ирснийг үзүүлэх төдийгүй, түүний харилцан нөлөөлөл, хөгжлийн үе шатны онцлог ялгаа, заагийг харуулж буй үзэгдэл гэж болно.

Дөрвөдүүд богино буюу хошин шог дуугаа ерөнхийд нь “мактаар” гэж нэрлэдгийн гол учир шалтгаан юунд оршиж байна вэ гэвэл ийм дууны ихэнх нь хайр сэтгэлт хүнээ магтан дуулсан байдаг. Магтаар дуу зохиогдохдоо хэн нэгэн хүн хайр сэтгэлт хүнээ санан мөрөөдөж, уулзаж учрах, нэгэн насны амьдралаа холбон сайн сайхан, аз жаргалтай, энх тунх амьдрах хүсэл сэтгэлдээ хөтлөгдөн, малын бэлчээр, ажил хөдөлмөрийн талбарт өөрийн эрхгүй магтаал шүлэг зохиож, түүнийгээ аялан дуулж эхэлдэг байна. Тэр нь хүний амнаас аманд дамжихдаа улам боловсон, төгөлдөржиж ардын “мактаар” дуу болж хувирдаг байна (Катуу, 2005, х.42-43).

Дарьганга, Үзэмчин ардын богино дуу ая, үгний хувьд бас л өвөрмөц. “Дарьганга ардын богино дууны аялгуу ихэвчлэн /мажорын/ арга эгшгийн байхад, Үзэмчин ардын богино дууны аялгуу ихэвчлэн /минорын/ билэг эгшгийн байдаг. Ер нь Дарьганга, Үзэмчин дуунуудын аялгуу нь сэтгэлд нийлэмжтэй, хүний сэтгэлийн маш нарийн эмзэг утсыг хөндөж чадахаар эгшиглэнтэй сонсогдохоос гадна, бие биеийнхээ аялгууг хэзээ ч давтаагүй байдаг юм (Чимэдцэе, 2012, х.6).

Монгол улсын Төрийн шагналт, хөгжмийн зохиолч Ц.Нацагдорж “Дуулах урлагийн хураангуй толь” бүтээлдээ “Монгол ардын богино дууны аялгуу байгууламжийн гол онцлог нь дууны шүлгийн үе өргөлт бүхэнд аялгууны хэмнэлийг нийцүүлж дуулахад оршино. Дууны шүлгийн бүтэц, аяын байгууламжаас шалтгаалан, Монгол ардын богино дууны хэлбэр, зохиомж янз бүр, угсаатан ястны дуунууд ч өөр өөрийн өвөрмөц онцлогийг хадгалсан аялга, хэмнэл, хэлбэр, бүтэцтэйгээр үүсч, хөгжиж иржээ” (Нацагдорж, 2010, х.72) хэмээн тодорхойлжээ.

Аялга хэмнэлийн ийм онцлог Өвөр монголын Ордос, Хянган, Жирэм, Улаан хад,

Альшаа, Баян-нуур зэрэг аймгийн ардын богино дуунд ч нэгэн адил хамаарагдана. Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, доктор (Sc.D), профессор Н.Жанцанноров дунд сургуулийн 5-р ангийн “Иргэний боловсрол” сурах бичигт зөвлөх багт ажиллахдаа тус сурах бичгийн агуулгад “Монгол богино дуу” сэдэв, агуулгыг боловсруулсан байна. Түүндээ “Ая, аялгууны хувьд авсаархан, өдөр тутмын ахуй амьдрал, аж байдал, санаа сэтгэлийг ихэвчлэн илэрхийлдэгээрээ богино дуу нэн түгээмэл. Богино дуу хэмжээний хувьд ихэвчлэн 3-5 бадагтай, бадаг бүр нь тодорхой нэг утга санааг ижил, төсөөтэй бадгаар тодотгож өгдөг. Богино дууг хөгжимтэй хавсран дуулахаас гадна хөгжимгүй ч дуулдаг. Богино дууг сэдэв, агуулгаар нь бүүвэйн дуу, элбэрэл, журмын дуу, аж байдлын дуу, хурим найр, зан үйлийн дуу, хошин шог дуу, хайр сэтгэлийн дуу, түүхэн дуу гэж ангилж болно” (Алтанзаяа, Амартүвшин, Бямбачулуун, Дэлгэрсайхан, Нарангэрэл, 2012, х.46) хэмээжээ.

### Судалгааны үр дүн

Дээр дурдсан судлаачдын тодорхойлолтоор Монгол ардын богино дууны сэдэв, агуулга нь хүний амьдралын бүхий л сэдэв агуулгыг хамаарч байдаг тул бүх насны хүмүүс дуулах боломжтойн дээр сэдэв, агуулга, төрөл хэлбэрийн хувьд ч баялаг болох нь тодорхой харагдаж байгаа бөгөөд харин дунд сургуулийн дуу хөгжмийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт тухайн суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон сэдэв, агуулга бүхий Монгол ардын богино дууг хэрхэн сонгон зааж сургах асуудал тодорхой бус тусгагдсан нь сурах бичиг болон сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйн харьцуулалтаас илэрлээ.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Монгол дунд сургуулийн сургалтын төлөвлөгөөний “Багшийн зохицуулах цаг”-ийн хүрээнд Монгол ардын богино дууг сурагчдад зааж өвлүүлэхийн тулд VII-IX ангийн сурагчдын онцлогт тохирсон Монгол ардын 30 богино дууг сонгон, сэдэв, агуулгын хувьд ангилахын зэрэгцээ тэдгээрийг ноотлон, хэлбэр, бүтэц (форма)-д анализ хийж үзэхэд дараах үр дүн гарав.

Дууны царааны хувьд гол үндсэн өнгөнүүд нь дөрөвц, тавц, наймц болон дээд тал нь наймц давсан дөрөвцийн зайнд дуулагдахаар байгаа бөгөөд нэг наймцаас дээш гарч байгаа гуравц, дөрөвцийн зайны өнгөний хувьд зөвхөн дайран өнгөрөх байдлаар дуулагдахаар байгаа учир 12-15 насны хүүхдийн хоолойнд тохиромжтой байгааг нь тогтоогдлоо. Мөн судалгааны үр дүнд эдгээр дууг сэдэв, агуулгын хувьд дараах 4 төрөл болгож, шинээр *ангилав*.

Хүснэгт 1. VII-IX ангийн сурагчдын онцлогт тохирсон Монгол ардын 30 богино дууг сэдэв, агуулгаар нь ангилвал:

Эх нутгийн сэдэвт дуу	Эцэг, эхийн элбэрэл журмын дуу	Найр наадмын дуу	Баатарлаг, гавьяат үйлсийн дуу
1. Тугалжин уул	11. Шар хад	20. Дөрвөн далай	29. Шишүү мээрэн
2. Уулын орой	12. Бөөрүүлэй	21. Тэнгэрийн салхи	30. Гаадай мээрэн
3. Торгууд нутаг	13. Агьтай толгой	22. Бөмбүүрээ	
4. Шар талын эх	14. Гандий мод	23. Алтан хундага	
5. Дааяа бөөр	15. Агь үгүй газар	24. Цэнхэр цагаан	
6. Хун галуу	16. Ар дэлхий	үүл	
7. Нуун заяа	17. Алтаргана	25. Цагаан сар	
8. Уулын орой	18. Сайхан	26. Хөгшин хоохон	
9. Сэр сэр салхи	19. Дэрсэн шарга	27. Журай гэлдэн	
10. Манай нутаг		28. Ёохор	

Тайлбар: БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хот, Хянган, Жирэм, Ордос аймгийн нутагт өргөн тархсан 100 гаруй дуунаас сонгов.

## Дүгнэлт

1. Монгол ардын богино дууг хадгалах, хамгаалах, хүүхэд залуучуудад зааж өвлүүлэх чиглэлээр онолын болон арга зүйн судалгаа дутмаг, ихэвчлэн энэ төрлийн дууны түүвэр, эмхэтгэл хэлбэрээр судалгааны эргэлтэд төдийлөн орохгүй байгаагийн нэг тод илрэл нь дунд сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, арга зүйд туйлын хангалтгүй тусгагдсан байхын сацуу багш болон сурагчдын мэдлэг ойлголт, хандлага хангалтгүй байгаа нь энэхүү судалгааны явцад илрэв.
2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Монгол дунд сургуулийн дуу хөгжмийн сургалтын хөтөлбөрт Монгол ардын богино дууны агуулга, арга зүйг тухайн бүс нутгийн онцлог болон энэ насны суралцагчийн онцлогт нийцэж байгаа эсэх талаар тусгай шалгуур, үзүүлэлтийг боловсруулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.
3. Монгол ардын богино дууг сурагчдад зааж өвлүүлэхдээ “Багшийн зохицуулах цаг”-ийн хүрээнд нэмэлт хөтөлбөрийг боловсруулахдаа дараах бүтэц, тогтолцоог дэвшүүлэн тавьж байна. Үүнд:
  - Монгол ардын богино дууны тухай мэдлэг ойлголт /бүс нутгийн онцлогтойгоор/
  - Монгол ардын богино дууны чиг үүрэг
  - Монгол ардын богино түүний бүтэц, төрөл, хэлбэр, дуулах хэв маягийн онцлог
  - Дунд сургуулийн VII-IX ангийн сурагчдын нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон Монгол ардын богино дуунуудыг шилж сонгох, түүний сэдэв, агуулга, арга зүй, сурагчийн хоолойн онцлогт нийцүүлэх /дуулах арга зүйд сургах/ гэх мэт.

## Ном зүй

- Алтанзаяа, Л., Амартүвшин, Б., Бямбачулуун, Л., Дэлгэрсайхан, Ц., Нарангэрэл, Р. (2012). Иргэний боловсрол V. Улаанбаатар.
- Бадраа, Ж. (1956). Хөгжмийн нэр томъёо. Улаанбаатар.
- Бадраа, Ж. (1998). Монгол ардын хөгжим. Улаанбаатар.
- Долгорсүрэн, Н. (2019). Монголын хөгжмийн сургалтын хөтөлбөрийн хөгжил, чиг хандлага, судалгаа, үр дүн. (Боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.
- Катуу, Б. (2005). Дөрвөд ардын найрын болон богино дуу. Улаанбаатар: Шинжлэх ухааны Академийн хэвлэх үйлдвэр.
- Нацагдорж, Ц. (2010). Дуулах урлагийн хураангуй тайлбар толь (Орос-Монгол, Монгол). Улаанбаатар: Экимто хэвлэлийн газар.
- Өрнөхдэлгэр, Д. (2014). Ойрад монголын аман зохиолын дээж. Улаанбаатар: Соёмбо притинг.
- Ринченсамбуу, Г. (1959). Монгол ардын дууны төрөл зүйл. Улаанбаатар: ШУДБХ Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар.
- Содном, Б. (1960). Монгол дууны түүхнээс. Улаанбаатар: ШУДБХ-ийн ЭШ-ний хэвлэх үйлдвэр.
- Хорлоо, П. (1981). Монгол ардын дууны яруу найраг (Төрөл зүйлийн бүрэлдэхүүний асуудлаар). Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Чимэдцэеэ, Ш. (2012). Жаахан шарга (Дарьганга үзэмчин ардын урт, богино дууны түүвэр). Улаанбаатар: Эзэн сүлд ХХК.
- Энэбиш, Ж. (2017). Монголын хөгжмийн их нүүдэл (Монгол хөгжим мэндэлсэн нь. Сурахуйн үүдэн) Уламжлалт хөгжмийн төрөл, зүйлийн судлал. Цуврал I. Улаанбаатар: Адмон принт.

## RESEARCH OF CHARACTERISTICS AND TYPES MONGOLIAN TRADITIONAL FOLK SHORT SONGS

<sup>a</sup>Chen Ning

<sup>a</sup>China, Inner Mongolia, Normal University, master

Corresponding author: [chenning034@gmail.com](mailto:chenning034@gmail.com) 

### **Abstract**

This article discusses the features, types, and importance of short songs, which are a type of Mongolian folk song. The traditional Mongolian folk singing is known to have two types, one being called the long song and the other called short songs. This is due to their style and different techniques of singing.

Short songs are often performed for more fast tuned songs, specially about loves, marriages and just about any daily happenings that traditionally took place on the steppe.

Because of that a short-song is a generic term for songs with a simple composition and compact form that can be sung by anyone.

The melody of the Mongolian short-song is mellifluous and easily remembered. Being transmitted from antiquity to the present day, folk short-songs can strike a deep chord in one's heart.

### **Keywords**

Music education, content, methodology, curriculum, textbook

---